



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/06

Өлгий

Г

Журам батлах тухай

Т

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67-р зүйлийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.“Алсын дуудлагаар эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэх журам”-ыг нэгдүгээр, “Алсын дуудлагын бэлэн байдлын хяналтын хуудас”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудаас аймгийн Нэгдсэн эмнэлэгт яаралтай тусламжаар өвчтөн шилжүүлэх маяг”-ыг гуравдугаар хавсралтаар, “Өвчтэй хүүхдийг шилжүүлэх маяг”-ыг дөрөвдүгээр хавсралтаар, “Жирэмсэн эмэгтэй шилжүүлэх маяг”-ыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нэгдсэн эмнэлгийн захирал, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.


3.Алсын дуудлагаар эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн (Х.Анжелика)-д даалгасугай.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг УТСХШҮМ-ийн хэлтсийн ахлах мэргэжилтэн (А.Ерганат)-д үүрэг болгосугай

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Х.ДАУЫРЖАН



Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны
.III дугаар сарын 20-ны өдрийн А/06
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



АЛСЫН ДУУДЛАГААР ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагаас аймгийн Нэгдсэн эмнэлэгт яаралтай тусламжийн дуудлага өгөх, хүлээн авах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, очиж тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Алсын дуудлагаар эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ өвчтөний эрхийг дээдлэн, нууцлал, аюулгүй байдал болон тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажиллана.
- 1.3. Үйлчлүүлэгчийн эрх, аюулгүй байдлыг дээдлэнэ.
- 1.4. Нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг шуурхай аюулгүй газар дээр нь үзүүлэх зарчмыг баримтална.
- 1.5. Эрүүл мэндийн ажилтны ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллана.
- 1.6. Энэхүү журмын дагуу алсын дуудлагаар эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд холбогдох хууль, тогтоол, журам, жагсаалт, тусламж, үйлчилгээнд мөрдөгдөх эмнэлзүйн заавар, стандартыг баримтална.

Хоёр. Алсын дуудлага дуудах

2.1. Алсын дуудлагыг зөвхөн тухайн Эрүүл мэндийн төвийн дарга, түүний эзгүйд нь даргыг орлож байгаа эмч өгнө. Сумын Эрүүл мэндийн төвийн дарга нь дуудлагыг шуурхай үнэлж, шаардлагатай мэдээллийг бэлдэнэ:

- Өвчтөний овог, нэр, нас, амин үзүүлэлтүүд
- Онош, суманд хийсэн эмчилгээ
- Өвчтөний байршил, дуудлага өгсөн цаг, минут
- Дуудлага өгч буй сумын Эрүүл мэндийн төвийн нэр, холбоо барих дугаар
- Хэрэв байгаа бол тухайн өвчтөний түүхийн товч мэдээлэл

2.2. Сумын ЭМТ-өөс өвчтнийг тээвэрлэхэд ЭМС-ын 2023 оны А/220 дугаар тушаал "Үйлчлүүлэгчийг аюулгүй тээвэрлэх журам"-ыг мөрдөнө.

2.3. Дуудлага дуудсан өвчтөнд өөрийн эмнэлгийн тусламжийн шатлалын түвшинд зайлшгүй шаардлагатай шинжилгээний урвалж, бодис, эм хэрэгсэл, тоног төхөөрөмж, мэс засал, төрөх өрөө, цахилгааны үүсгэвэр, цусны донор, нэмэлт хүний нөөцийг бэлэн байдлыг ханган ажиллах ба өвчтөнд зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, цусан бүтээгдэхүүний өртөг зардлыг Нэгдсэн эмнэлгийн нэмэмжлэхийн дагуу шилжүүлэх үүрэгтэй

- 2.4. Дуудлагын эмч багийн аюулгүй байдал, амрах байр, хоол унд, гражаар хангана.
- 2.5. Өөрийн эмнэлэгт үзүүлэх боломжтой тусламж, үйлчилгээнд болон ар гэрийн шахалтаар алсын дуудлага дуудахгүй бөгөөд үүнээс үүдэн гарсан зардлыг дуудлага дуудаж буй Эрүүл мэндийн төвийн хариуцан гаргана.
- 2.6. Нэгдсэн эмнэлгийн хүлээн авах алба /7042103/ дуудлагыг хүлээн авч бүртгэнэ.
- 2.7. Нэгдсэн эмнэлгийн мэргэжилтэн заавар, зөвлөгөө өгч, шаардлагатай тохиолдолд эмнэлэгт бэлтгэл хангана.
- 2.8. Дуудлагын мэдээллийг баримтжуулж, албан тэмдэглэлд бүртгэнэ.
- 2.9. Өвчтөний хувийн мэдээллийг зөвхөн эмнэлгийн ажилтнууд ашиглах бөгөөд гуравдагч этгээдэд мэдээлэхгүй

Гурав.Алсын түргэн тусламжийн дуудлага хүлээн авах:

- 3.1. Аймгийн нэгдсэн эмнэлэг СЭМТөвийн алсын дуудлагыг Нэгдсэн эмнэлгийн 7042103 утсаар 24 цагийн турш тасралтгүй бүртгэж хүлээн авна.
- 3.2. Алсын дуудлага ирсэн даруйд дуудлага зохицуулагч ажилтан 10 минутын дотор Нэгдсэн эмнэлгийн ЭЭДЗахиралд / захирлын эзгүйд бусад захирлууд/ танилцуулж мэдээллийг хүргэн шийдвэрлүүлнэ.

Дөрөв.Алсын дуудлагыг шийдвэрлэх:

- 4.1. ЭЭДЗахирал /ЭЭДЗахирлыг эзгүйд бусад захирлууд / алсын дуудлагатай танилцан шаардлагатай нэмэлт мэдээллийг авч дүгнэн эмч, алсын дуудлагын багийг томилох, эсвэл төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө өгүүлэх асуудлыг шийдэж, шийдвэрийг дуудлага зохиуцуулагчид мэдэгдэнэ.
- 4.2. Зөвлөгөө өгөх тохиолдолд төрөлжсөн мэргэжлийн зөвлөх эмч, мэргэжлийн зэрэгтэй эмч нар интернет технологи, утас ашиглан зөвлөгөө өгч эмнэл зүйн зөвлөгөөний шийдвэрийг дуудлага зохиуцуулагч болон дуудлага шийдвэрлэсэн албан тушаалтанд мэдэгдэнэ.
- 4.3. Дуудлага зохиуцуулагч алсын дуудлагын томилогдсон багийг идэвхижүүлж дуудлагын хуудсыг дугаарлан олгож дуудлагын багт аюулгүй байдлын зааварчилгаа өгч, жолоочид эрүүл мэндийн үзлэг хийж баталгаажуулна.

Тав.Алсын дуудлагын үйл ажиллагааны зохион байгуулалт:

- ЭЭДЗахирал сар бүр мэргэжлийн чиглэлээр алсын дуудлага гүйцэтгэх эмч сувилагч, жолоочийн хуваарийг батлан мөрдөж ажиллана.
- Шаардлагатай тохиолдолд нөхөн томилгоо болон нэмэлтээр алсын дуудлагат явах эмч багийг томилох эм эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах үүргийг ЭЭДЗ хариуцна .
- Багийн ахлагчийг дуудлага шийдэрлэсэн албан тушаалтан ЭЭДЗахирал томилно.
- Алсын дуудлагын цүнхний бэлэн байдалд ЯТТ ахлах сувилагч тогтмол

- хяналт тавиж, бэлэн байдлыг бүрдүүлнэ.
- Автомашиныг тенхикийн үзлэгт жил бүр оруулан аюулгүй бэлэн байдлыг хангасан байна.
- Алсын дуудлагын эмч мэргэжилтэнг гэнэтийн ослын даатгал, хариуцлагын даатгалд жил бүр хамруулна.
- Алсын дуудлагат томилогдсон баг Нэгдсэн эмнэлгийн захирлын тушаалын дагуу Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа авах ба багийн гишүүдийг гарын үсэг зуруулж баталгаажуулна
- ЭТҮЧАБА нь алсын дуудлагын үйл ажиллагааг зохицуулах журмын хэрэгжилт, бэлэн байдалд жил бүр хяналт үнэлгээ хийнэ.
- Багийн гишүүд байгаль цаг уурын нөхцөл байдалд тохируулан хувийн бэлтгэлийг хангасан байна .
- Алсын дуудлаганд томилогдсон баг нэг цагийн дотор бэлэн байдлыг хангаж дуудлаганд гарна.
- Баг газар дээр эмнэл зүйн тусламж үйлчилгээг багаар үзүүлэх бөгөөд ХСХ, эмнэлзүйн стандарт удардамж, эмч эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чанд баримтлан ажиллана.
- Эмч мэргэжилтнүүд ажил үүргээ гүйцэтгэх үедээ ажлын хувцасаа бүрэн өмсөж нэр албан тушаал бүхий энгэрийн тэмдэг хэрэглэнэ.
- Эмчлүүлэгчийг лавалгаа шатлалд тээвэрлэхдээ тухайн шилжүүлж байгаа эмнэлгийн байгууллагат мэдэгдэн бэлэн байдлыг ханган эмнэлэг хүртэлх тусламжийг тасралтгүй үзүүлэн тээвэрлэнэ.
- Дуудлагын эмч, баг албан бус төлбөр /урсгуур, цус тогтоох губка, гипс, чиг, мэс заслын утас гэх мэт/ авахыг хатуу хориглоно.
- Архи согтууруулах ундаа хэрэглэсэн эмч эмнэлгийн мэргэжилтэн, жолоочийг алсын дуудлагад явуулахгүй бөгөөд дараагийн баг, эмч мэргэжилтэнг томилно
- Дуудлагын эмч, баг дуудлагын хуудас томилолтыг дуудлага дуудсан ЭМТ-өөр баталгаажуулна.

Зургаа. Алсын дуудлаганд ажиллах мэргэжлийн багийн үүрэг хариуцлага

6.1.Багийн ахлагчийн үүрэг:

- Багийн ахлагч ЭЭДЗахирал болон дуудлага өгсөн СЭМТ-ийн эмчээс өвчтөний биеийн байдал, тусламж үйлчилгээ үзүүлэх бэлэн байдал нөхцөлтэй танилцаж, зайлшгүй шаардлагатай эм, цус цусан бүтээгдэхүүн, эмнэлгийн багаж хэрэгслийг нэмэлтээр авч явж болно.
- Дуудлагын ахлах эмч өвчтний эмчлэгч эмчид дуудлага очтол үргэлжүүлэнавах арга хэмжээний санал зөвлөмж өгч болно.
- Багийн ахлагч эмнэл зүйн асуудлыг багийн болон СЭМТөвийн эмч нартайхамтарсан үзлэг зөвөлгөөн хийж шийдвэр гаргана.
- Алсын дуудлагын багийн ахлагч эмч үйлчлүүлэгийн ар гэрт өвчтний биеийн байдал, онош, авч хэрэгжүүлсэн эмнэл зүйн үйл ажиллганы талаар бүрэн дүүрэн мэдээлэл өгнө.
- Алсын дуудлагын эмч, баг тусламж үзүүлсэн үйлчлүүлэгчийн биеийн

байдлын талаар эмчлэгч эмчтэй холбогдож эргэх холбоотой ажиллана.

- Алсын дуудлагын гүйцэтгэлийг буцаж ирсэнээс хойш 1 хоног дотор программд алсын дуудлагын хуудсыг бөглөж ЭЭДЗ-д танилцуулж баталгаажуулна.
- Бусад үүрэг хариуцлага

6.2. Эмч нарын үүрэг хариуцлага :

- Тухайн өдрийн алсын дуудлагын хуваарьт тавигдсан эмч өөрийн ажлаа бүрэн зохицуулсан, алсын дуудлагад явахад бэлэн байдалд байна. Зайлшгүй шаардлагаар чөлөөлөгдсөн тохиолдолд дуудлага зохицуулагч болон ЭЭДЗ-д мэдэгдэж орлон ажиллах эмчийн томилгоог хийлгэсэн байна.
- Алсын дуудлаганд томилогдсон эмч, дуудлагын мэдээлэлтэй танилцаж нэг цагийн дотор бэлэн байдлыг ханган дуудлагад гарна.
- Өвчтөнд эмнэлгийн шаардлагатай тусламжийг стандарт удирдамжийн дагуу үзүүлж өвчтөний түүхэнд тэмдэглэн баталгаажуулна.
- Өвчтөн түүний асран хамгаалагчаас шаардлагатай бүх тохиолдолд зөвшөөрөл авч баталгаажуулна.

6.3. Сувилагч нарын үүрэг хариуцлага :

- Тухайн өдрийн алсын дуудлагын хуваарьт тавигдсан сувилагч өөрийн ажлаа бүрэн зохицуулсан, алсын дуудлагад явахад бэлэн байдалд байна. Зайлшгүй шаардлагаар чөлөөлөгдсөн тохиолдолд дуудлага зохицуулагч болон ЭЭДЗ-д мэдэгдэж орлон ажиллах сувилагчийн томилгоог хийлгэсэн байна.
- Эм, эмнэлгийн хэрэгсэл, нэг удаагийн хэрэгслийн нөөцийг бүрэн хангаж эмчдээ хянуулж бэлэн байдлаа хангаж явна.
- Сувилагч нь тухайн дуудлагат шаарлагатай цус цусан бүтээгдэхүүн, шинэ хөлдөөсөн сийвэнг бэлтгэх, хэрэглэсэн тохиолдолд тооцоог хариуцах, хэрэглээгүй тохиолдолд бүтээгдэхүүний аюулгүй байдлыг ханган буцааж цусны салбар төвд хүлээлгэн өгнө.
- Өвчтөнд шаардлагатай сувилахуйн тусламжийг стандарт удирдамжийн дагуу бүрэн үзүүлж, өвчтөний түүхэнд журмын дагуу тэмдэглэн баталгаажуулна.
- Бусад үүрэг хариуцлага

6.4. Алсын дуудлагын жолоочийн үүрэг хариуцлага :

- Жолооч жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байх ба дуудлагад гарахын өмнө эрүүл мэндийн үзлэгт орно.
- Алсын дуудлагын жолооч нь газар зүй, замын байрлалын талаар мэдлэгтэй, дадлага туршлагатай, амилуулах суурь тусламж үзүүлэхэд хамтран ажиллах чавдартай байна
- Алсын түргэн тусламжийн дуудлаганд гарахаас өмнө тээврийн хэрэгсэлд техникийн үзлэг хийж, аюулгүй байдлыг хангана.
- Ерөнхий санхүүчийн цохолтоор шатахуун, тослох материалыг тарифт заасны дагуу авч бэлэн байдлыг хангаж ажиллана.

- Түргэн тусламжийн үйлчилгээг MNS 6717:2018 үндэсний стандартад заасан туулах чадвартай, өвчтөн тээвэрлэхэд зориулагдсан тоноглол бүхий зориулалтын автомашинаар үйлчилнэ.
- Алсын дуудлагын багийг ажлын цагаар ажлын байран дээрээс, бусад үед байгаа байршилаас нь очиж авна.
- Жолооч нь орон нутагт очих болон буцах тухайгаа дуудлага зохицуулагч ажилтанд мэдээлнэ.
- Алсын дуудлагат явах, ирэхдээ спидометрийн заалт, шатахууны үлдэгдлийг ажлын хуудсанд бүртгэн дуудлага зохицуулагчид хүлээлгэн өгнө.
- Дуудлагын машинд өвчтөн, асран хамгаалагч дуудлагын эмч багийн гишүүдээс өөр зорчигч тээвэрлэхийг хатуу хориглоно.

Долоо. Алсын түргэн тусламжийн дуудлагыг дүгнэж тайлагнах

- Дуудлаганд явсан багийн ахлагч, мэргэжилтэн нь тусламж үйлчилгээ хэрхэн хүргэсэн талаар ажлын тайланг бичиж дуудлагын хуудсыг бөглөж 1 хоног дотор /e-health программд шивж/ ЭЭДЗахиралд танилцуулна.
- Тусламж авсан өвчтний түүхийг шаардлагатай тохиолдолд /өвчтөн нас барсан, гэмт хэргийн шинжтэй, эхийн ноцтой хүндрэл, ховор тохиолдол/ хуулбарлан бэхжүүлж ЭТҮЧАБА, ГУДХА-д ирүүлэн чанар төлбөрийн хяналт хийлгэж үнэлүүлнэ.
- Алсын дуудлага гүйцэтгэсэн эмч, багийн ахлагч гүйцэтгэсэн ажил үүргийн талаарх мэдээллийг ЭЭДЗахиралд тайлагнан дуудлагын хуудас томилолтыг гарын үсэг зурж баталгаажуулж санхүүд хүлээлгэн өгснөөр алсын дуудлага гүйцэтгэсэн хөлс олгогдох эрх үүснэ.

Найм. Хариуцлага

- Энэ журмыг зохих ёсоор биелүүлээгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуваарийн дагуу ажиллаагүй цаг хугацаа оройтуулсан эмч мэргэжилтэнд байгууллагын дотоод журам, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.
- ХАБЗаавар өгч баталгаажуулаагүйгээр алсын дуудлагат гаргасан бол дуудлага зохицуулагч ажилтан хариуцлага хүлээнэ.
- Шаардагагүй дуудлага дуудсан, журмын холбогдох хэсгийг биелүүлээгүй ЭМБайгууллагын тохиолдлыг ЭМГазарт мэдэгдэн шийдвэрлүүлнэ.

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны
 01 дугаар сарын 10-ны өдрийн 4/ав.
 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

АЛСЫН ДУУДЛАГЫН БЭЛЭН БАЙДЛЫН ХЯНАЛТЫН ХУУДАС

Жолоочийн овог нэр:.....

Тээврийн хэрэгслийн дугаар:.....

Жолоочийн эрүүл мэндийн үзлэг

№	Үзлэгийн төрөл	Шаардлага	Шалгуур хангасан		Тайлбар
			Тийм	Үгүй	
Нэг. Ерөнхий үзлэг					
1	Цусны даралт	Цусны даралт хэвийн (даралтыг 2 гарт 3 удаа үзэж тэмдэглэх)			
2	Зүрх судасны тогтолцоо	Хэвийн			
3	Амьсгалын тогтолцоо	Хэвийн			
4	Яс булчингийн тогтолцоо	Хэвийн			
5	Согтууруулах ундааг сүүлийн 3 хоногт хэрэглэсэн эсэх	Үгүй			

Эрүүл мэндээр тэнцэнэ, тэнцэхгүй /зур/ Зөвшөөрсөн:
/жолооч/

Дуудлага зохицуулах ажилтан:...../

/гарын үсэг/ /овог, нэр/

Огноо, цаг минут:.....


Автомашин үзлэг

№	Шалгах эд анги	Шалгуур	Шалгуур хангасан		Тайлбар
			Тийм	Үгүй	
Нэг. Цахилгаан, гэрэл дохио					
1	Их гэрэл	Асах			
2	Ойрын гэрэл	Асах			
3	Оворын гэрэл	Асах			
4	Дохио, аваарын гэрэл	Асах, анивчих			

5	Акумуляторийн цэнэг	12 вольт			
6	Цахилгаан холбогч	Байгаа			
7	Автомашин дуут дохио	Дуугарах			
8	Тусгай гэрэл, дуут дохио	Асах, дуугарах			
9	Ослын гэрэлт пуужин	3ш			
10	Зөөврийн гэрэл	1ш			
Хоёр. Мотор, тос, түлш					
11	Моторын тосны түвшинг шалгах	Дээд доод түвшний дунд			
12	Залах хүрдний шингэн шалгах /руль/	Дээд доод түвшний дунд			
13	Тормосны систем шалгах /шингэн, хоолой, накладка/	Дээд доод түвшний дунд			
14	Моторын хөргөлтийн шингэний түвшинг шалгах	Таглаагаар харагдах			
15	Хурдны хайрцагны тосны түвшин	Дээд доод түвшний дунд			
16	Моторын асалт	Сайн			
17	Түлшний сав	Гоожоогүй			
18	Нөөц түлшний сав	Гоожихгүй, таг сайн			
19	Нөөц түлш /бензин/	20 л			
20	Дулаан үлээгч	ажилладаг			
Гурав. Дугуй, зогсоох систем					
21	Дугуйны хийн даралт	Урд 2,7 кг/см ²			
22		Хойд 2,7 кг/см ²			
23	Нөөц дугуй	2ш			
24	Нөөц олгой хамер	2ш			
25	Дугуйн хээний хэмжээ	0,8 см-ээс дээш			
26	Тормос сайн	4 дугуй зэрэг			
27	Гар тормос	Ажилладаг			
28	Автомат дугуй хийлэгч	1ш			
29	Дугуйн нөхөөс	1 ком			
30	Дугуйн ивүүр төмөр	2ш			
Дөрөв. Эмнэлгийн тусламжийн хэрэгсэл					
31	Жолоочийн эмнэлгийн анхан шатны тусламжийн иж бүрдэл	1ш			
32	Угсардаг насилк	1ш			
33	Чиг баригч	Хөлний-3ш			
		Гарны-3ш			
		Хүзүүний-3ш			

		Нурууны-3ш			
34	Ариутгасан ороох боох материал	5ком			
Тав. Багаж, бусад хэрэгсэл					
35	Түлхүүр, багаж	Хангалттай			
36	Галын хор	1ш			
37	Ослын зогсолтын гурвалжин тэмдэг	1ш			
38	Зөөлөн татлага, чирэгч трос	1ш			
39	Байршил тогтоогч GPS аяллын цахим хөтөч	1ш			
40	Дулаан хувцас (өвлийн улиралд дах дэгтий, машины бүтээлэг)	1ш			
41	Тахлын хувцас	3ш			
42	Ариутгалын бодис	2л			
43	Зөөврийн, түлш бензинээр ажилладаг дулаан үүсгүүр	1ш			
44	Майхан, аяны хөнжил	1ш			
45	Гэрэлтүүлэгч	1ш			
46	Замын хүнс	2 хүн, 2 өдрийн			
47	Холбооны утас /шаардлагатай тохиолдолд/	1ш			
48	Зургийн аппарат /шаардлагатай тохиолдолд/	1ш			
49	Газын плитка (нөөц газтай) /шаардлагатай тохиолдолд/	1ш			
<p>Автомашинны техникийн үзүүлэлт тэнцэнэ, тэнцэхгүй /зур/</p> <p>Аж ахуй хариуцсан менежер:/ /</p> <p>Огноо, цаг минут:</p>					

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны
... дугаар сарын ...-ны өдрийн ...
дугаар тушаалын гуравдугаар хавсралт



СУМЫН ЭМТ-ӨӨС АЙМГИЙН НЭ-Т ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖААР ӨВЧТӨН
ШИЛЖҮҮЛЭХ МАЯГТ

1. ӨВЧТӨНИЙ ЯАРАЛТАЙ МЭДЭЭЛЭЛ

- Овог, нэр: _____
- Нас: _____ Хүйс: _____
- Регистрийн дугаар: _____
- Оршин суугаа хаяг: _____
- Холбоо барих утас (өөрийн/асран хамгаалагч): _____

2. ИЛГЭЭГЧ БАЙГУУЛЛАГА

- Илгээж буй ЭМТ: _____
- Эмчийн нэр, албан тушаал: _____
- Холбоо барих утас: _____

3. ЯАРАЛТАЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

- Ухамсар: Сэрүүн Манарсан Ухаангүй
- Амьсгал: _____ /мин SpO₂: _____ %
- Судасны цохилт: _____ /мин
- Артерийн даралт: _____ / _____ мм.муб
- Температур: _____ °C

4. ОДООГИЙН ОНОШ, БАЙДАЛ

- Урьдчилсан онош: _____
- Гол зовиур, шинж тэмдэг: _____
- Өвчний явц, эхэлсэн хугацаа: _____

5. ХИЙГДСЭН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ, ЭМЧИЛГЭЭ

- Эмийн эмчилгээ: _____
- Судсаар хийсэн шингэн/эм: _____
- Амьсгал дэмжих арга хэмжээ: _____
- Бусад арга хэмжээ: _____

6. ХИЙГДСЭН ШИНЖИЛГЭЭ, ОНОШИЛГОО

(хавсаргасан баримт бичгийг тэмдэглэнэ)

- Лабораторийн шинжилгээ: _____

7. ШИЛЖҮҮЛЖ БУЙ ШАЛТГААН

- Эрчимт эмчилгээ шаардлагатай
- Мэс заслын тусламж шаардлагатай
- Нарийн мэргэжлийн тусламж шаардлагатай
- Оношийг тодруулах шаардлагатай
- Бусад: _____

8. ТЭЭВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

- Тээвэрлэлтийн хэлбэр: Түргэн тусламж Энгийн Өөрөө
- Дагаж яваа эмнэлгийн ажилтан: _____
- Тээвэрлэх үеийн байдал тогтвортой эсэх: Тийм Үгүй
- Эрсдэл, анхаарах зүйл: _____

9. ХАВСРАЛТ БАРИМТ БИЧИГ

- Эмнэлгийн түүхийн хуулбар
- Шинжилгээний хариу
- ЗЦБ
- Бусад: _____

10. ЭМЧИЙН БАТАЛГАА

Илгээсэн эмчийн нэр: _____
Гарын үсэг: _____ Огноо: ____ / ____ / ____

ЭМТ-ийн тамга:

11. ХҮЛЭЭН АВСАН БАЙГУУЛЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Хүлээн авсан эмчийн нэр: _____ Гарын үсэг: _____
Огноо: ____ / ____ / ____

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны
... дугаар сарын ...-ны өдрийн ...
дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



ӨВЧТЭЙ ХҮҮХДИЙГ ШИЛЖҮҮЛЭХ МАЯГТ

1. ХҮҮХДИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

- Овог, нэр: _____
- Нас: _____ Сар: _____ Хүйс: _____
- Регистрийн дугаар: _____
- Оршин суугаа хаяг: _____
- Асран хамгаалагчийн нэр, утас: _____

2. ИЛГЭЭГЧ БАЙГУУЛЛАГА

- Илгээж буй СЭМТ: _____
- Эмчийн нэр, албан тушаал: _____
- Холбоо барих утас: _____

3. ОДООГИЙН БАЙДАЛ (ХҮҮХДИЙН ҮНЭЛГЭЭ)

- Ухамсар: Сэрүүн Манарсан Ухаангүй
- Амьсгал: _____ /мин SpO₂: _____ %
- Зүрхний цохилт: _____ /мин
- Артерийн даралт: _____ / _____ мм.муб
- Температур: _____ °C
- Жин: _____ кг

4. ОНОШ, ӨВЧНИЙ ЯВЦ

- Урьдчилсан онош: _____
- Гол зовиур, шинж тэмдэг: _____
- Өвчний эхэлсэн хугацаа, явц: _____

5. ХИЙГДСЭН ЭМЧИЛГЭЭ

- Эмийн эмчилгээ (тун, хугацаа): _____
- Судсаар шингэн: _____
- Бусад арга хэмжээ: _____

6. ХИЙГДСЭН ШИНЖИЛГЭЭ

- Лаборатори: _____

7. ШИЛЖҮҮЛЖ БУЙ ШАЛТГААН

- Эрчимт эмчилгээ шаардлагатай
- Мэс заслын тусламж шаардлагатай
- Нарийн мэргэжлийн тусламж шаардлагатай
- Бусад: _____

8. ТЭЭВЭРЛЭЛТ

- Тээвэрлэлтийн хэлбэр: Түргэн тусламж Энгийн Өөрөө
- Дагаж яваа эмнэлгийн ажилтан: _____
- Асран хамгаалагч дагалдах эсэх: Тийм Үгүй

9. ХАВСРАЛТ БАРИМТ БИЧИГ

- Эмнэлгийн түүхний хуулбар
- Дархлаажуулалтын дэвтэр
- Шинжилгээний хариу
- Дүрс оношилгооны хариу
- Бусад: _____

10. ЭМЧИЙН БАТАЛГАА

Илгээсэн эмчийн нэр: _____
Гарын үсэг: _____ Огноо: ____ / ____ / ____

ЭМТ-ийн тамга:

11. ХҮЛЭЭН АВСАН БАЙГУУЛЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Хүлээн авсан эмчийн нэр: _____ Гарын үсэг: _____
Огноо: ____ / ____ / ____

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны
01 дугаар сарын 30-ны өдрийн 4/06
дугаар тушаалын гавдугаар хавсралт



ЖИРЭМСЭН ЭМЭГТЭЙ ШИЛЖҮҮЛЭХ МАЯГТ

1. ЖИРЭМСЭН ЭМЭГТЭЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

- Овог, нэр: _____
- Нас: _____ Регистрийн дугаар: _____
- Оршин суугаа хаяг: _____
- Холбоо барих утас: _____

2. ЭХ БАРИХЫН МЭДЭЭЛЭЛ

- Жирэмсний хугацаа: _____ долоо хоног
- Төрөлт: Анхны Давтан (____ удаа)
- Өмнөх жирэмслэлт, төрөлтийн хүндрэл: _____

3. ОДООГИЙН БАЙДАЛ

- Ухамсар: Сэрүүн Манарсан Ухаангүй
- Артерийн даралт: _____ / _____ мм.муб
- Зүрхний цохилт: _____ /мин
- Температур: _____ °C
- Умайн агшилт: Байгаа Байхгүй Давтамж: _____
- Ургийн зүрхний цохилт: _____ /мин
- Үтрээний цус алдалт: Байгаа Байхгүй

4. ОНОШ, ЭМНЭЛЗҮЙН БАЙДАЛ

- Урьдчилсан онош: _____
- Гол зовиур, хүндрэл: _____

5. ХИЙГДСЭН ЭМЧИЛГЭЭ, АРГА ХЭМЖЭЭ

- Эмийн эмчилгээ: _____
- Судсаар хийсэн шингэн/эм: _____
- Бусад арга хэмжээ: _____

6. ХИЙГДСЭН ШИНЖИЛГЭЭ

- Лаборатори: _____
- УЗИ: _____

7. ШИЛЖҮҮЛЖ БУЙ ШАЛТГААН

- Өндөр эрсдэлтэй жирэмслэлт
- Хүндрэлтэй төрөлт
- Мэс заслын тусламж шаардлагатай

Эрчимт эмчилгээ шаардлагатай

Бусад: _____

8. ТЭЭВЭРЛЭЛТ

- Тээвэрлэлтийн хэлбэр: Түргэн тусламж Энгийн Өөрөө
- Дагаж яваа эмнэлгийн ажилтан: _____

9. ХАВСРАЛТ БАРИМТ БИЧИГ

Жирэмсний хяналтын дэвтэр

Шинжилгээний хариу

УЗИ-ийн дүгнэлт

Бусад: _____

10. ЭМЧИЙН БАТАЛГАА

Илгээсэн эмчийн нэр: _____

Гарын үсэг: _____ Огноо: ____ / ____ / ____

ЭМТ-ийн тамга:

11. ХҮЛЭЭН АВСАН БАЙГУУЛЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Хүлээн авсан байгууллага: _____ Хүлээн авсан эмчийн
нэр: _____

Огноо: ____ / ____ / ____ Гарын үсэг: _____

Тайлбар: Эдгээр маягтуудыг өвчтөнг аймгийн нэгдсэн эмнэлэгт шилжүүлэх үед заавал бөглөж, холбогдох бүх баримт бичгийг хавсаргана.